Сувилахуйн сургуулийн оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг судалсан нь

Б.Мөнхтуяа[1], Г.Ганхуяг[1], Б.Оюунгоо[1]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль
Цахим шуудан: munkhtuya.ba@mnums.edu.mn, Утас: 98111985

Түлхүүр үг:

Өөрийгөө үнэлэх үнэлэмж
Хувийн үнэт зүйлс
Үнэлэх сорил

Товч утга:

Үндэслэл: Суралцахуйн нөөц, чадвар хүн бүрт байдаг бөгөөд хүн өөрийгөө танин мэдэх, юмсын учир холбогдлыг өөрөө олж мэдэх, өөрийгөө үнэлэх замаар сонирхол, хэрэгцээ, авъяас чадвараа нээн илрүүлэх өөрийгөө хөгжүүлэх асуудал нь өрнө дорнын үе үеийн сэтгэгчдийн дэвшүүлсэн философи үзэл баримтлал онол сургаальд чухал байр суурь эзлэсээр ирсэн. Суралцахуйн үндэс нь хүн өөрийгөө танин мэдэх, нээн илрүүлэхээс эхлэлтэй тул амжилттай суралцахад өөрийгөө үнэлэх үнэлэмж онцгой чухал үүрэгтэй[1]. Бие хүн хөгжин төлөвших үйл явц түүний үр дүн нь тухайн хүний өөрийнх нь идэвх оролцоо, өөртөө тавих шаардлага, өөрийгөө үнэлэх үнэлэмж зэргээс ихээхэн шалтгаална. Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хүндлэх, өөртөө итгэлтэй байх энэхүү хэрэгцээ нь хүний амьдралын туршид байнга өсөн нэмэгдэж байдаг. Бүхий л үе шатанд хүмүүс амьдралын утга учрыг эргэцүүлэн өөрт нь хамгийн чухал юм юу болохыг хайж эрэлхийлж байдаг байна[2]. **Зорилго:** Сувилахуйн оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг тодорхойлох. **Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг SPSS-25 программ, Microsoft Exsel программуудыг ашиглан өгөгдлийг кодлож, алдааг шалгасны дараа боловсруулалтыг хийв. **Үр дүн:** Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн 356 (48.6%) оюутан, сувилахуйн дипломын хөтөлбөрийн 377 (51.4%) оюутан, нийт 17-43 насны 733 оюутан хамрагдсан бөгөөд дундаж нас нь 21.2±4.2 жил байв. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 49 (6.68%) нь өөрийгөө үнэлэх үнэлэмж маш өндөр, 55 (7.5%) нь өөрийгөө үнэлэх үнэлэмж дунджаас дээгүүр түвшинд, 142 (19.4%) нь өөрийгөө үнэлэх үнэлэмж дундаж түвшинд, 487 (66.4%) нь өөрийгөө үнэлэх үнэлэмж маш бага гэж үнэлсэн. **Дүгнэлт:** Оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмж маш бага (66.4%) байна. Энэ нь тэдний нас, болон нийгэмд эзлэх байр суурь, мөн хүрээлэн буй орчны нөлөөлөл, ар гэр, багш, эцэг эхийн оролцоотой холбоотой байх магадлалтай учраас оюутан хэмээх бие хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж хөгжиж төлөвших насанд нь өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх хэрэгцээ байна.

Үндэслэл: XXI зууны бүх шатны боловсролын үндсэн зорилго, зорилт нь хувь хүнд шинэ зуунд сурч амьдрахад шаардлагатай бүх нийтийн насан туршийн боловсролын компетенцийг төлөвшүүлэхэд чиглэж байна. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго нь иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино.[3] UNESCO (ЮНЕСКО)-ийн боловсролын бодлогын үзэл баримтлалд “Мэдэхэд суралцах, хийхэд суралцах, оршин байхад суралцах, хамтдаа амьдрахад суралцах” хэмээн суралцагчийн эзэмшвэл зохих цогц чадамжийг тодорхойлсон байна. Дэлхийн иргэний боловсрол (ДИБ) нь ЮНЕСКО-ийн Боловсролын хөтөлбөрийн

стратегийн нэг чиглэл бөгөөд энх тайван, хүний эрхийн боловсролын чиглэлээр хийгдсэн ажлууд дээр тулгуурладаг. Хариуцлагатай дэлхийн иргэнийг дэмжих, бүтээлч сэтгэлгээ, инновац, энх тайван, хүний эрх, тогтвортой хөгжлийг цогцлоох үнэт зүйл, хандлага, зан төлөвийг суралцагчдад төлөвшүүлэхийг зорьдог.[2]


Оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр байх нь тэдний сурлагын амжилт, ирээдүйн чадварлаг мэргэжилтэн байх үндэс болдог нь ихэнх судалгаагаар батлагдсан байдаг бөгөөд манай орны хувьд сувилахуйн хөтөлбөрийг сонгон суралцаж буй оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг судалсан судалгаа ховор байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Сувилахуйн оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийн түвшинг судлах

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар, зорилтот түүврийн аргыг сонгон асуумж судалгааны аргаар 2022 оны 04 дүгээр сараас 2023 оны 02 сар хүртэлх хугацаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийг түшиглэн хийсэн. АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022 оны 03 сарын 25-ны өдрийн хурлын №2022/3-03 тоот шийдвэрээр судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл авсан. Судалгаанд 50 асуумж бүхий Мэйрлин Соренсений стандарт сорил болон нэмэлтээр хүн амзүйн мэдээллийн 15 асуумж боловсруулан ашигласан. Судалгааны үзүүлэлтүүдийг компьютерийн Microsoft Word, Microsoft Exsel программуудыг ашиглан мэдээллийг нэгтгэж SPSS-25 программыг ашиглан тойм болон нарийвчилсан статистик боловсруулалт хийсэн.

Үр дүн: Судалгаанд нийт 733 оюутан хамрагдсанаас 17-21 насны 580 (79.1%), 22-43 насны 153 (20.9%), Улаанбаатар хотын харъяалалтай 267 (36.4 %), хөдөө орон нутгийн харьяалалтай 466 (63.6%), эмэгтэй 725 (98.9%), эрэгтэй 8 (1.1%), нэгдүгээр дамжааны 183 (25%), хоёрдугаар дамжааны 243 (33.2%), гуравдугаар дамжааны 243 (33.2%), дөрөвдүгээр дамжааны 64 (8.7%), бакалаврын 356 (48.6%), дипломын 377 (51.4%), өөрийн гэрт 398 (39.3%), оюутны байр болон түрээсийн байр, танил айлд амьдардаг 335 (60.7%), 1-3 ам бүлтэй 182 (24.8%), 4-6 ам бүлтэй 462 (63%), 7-9 ам бүлтэй 83 (11.3%), 10- аас дээш ам бүлтэй 6 (0.8%), айлын ууган хүүхэд 223 (30.4%), айлын дунд хүүхэд 251 (34.2%), айлын бага хүүхэд 231 (31.5%), айлын ганц хүүхэд 28 (3.8%), хагас болон бүтэн өнчин 209 (28.5%), бусдад үрчлэгдсэн болон хойд аав, хойд ээжийн хамт амьдардаг 72 (9.9%), гэр бүл болсон 97 (13.2%), гэр бүл болоогүй 636 (86.8%) оюутан судалгаанд хамрагдсан бол элсэлтийн ерөнхий шалгалтанд химийн хичээлийн босго оноог (501-ээс дээш) давсан 272 (37.1%), биологийн хичээлийн босго оноог (501-ээс дээш) давсан 290 (39.6%), физикийн хичээлийн босго оноог (501-ээс дээш) давсан 34 (4.6%), англи хэлний хичээлийн босго оноог (501-ээс дээш) давсан 93 (12.7%), математикийн хичээлийн босго оноог (501-ээс дээш) давсан 77 (10.5%) оюутанууд тус тус хамрагдлаа.

Оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийн түвшинг хүн ам зүйн ерөнхий үзүүлэлттэй харьцуулан үзэхэд хүйс (p=0.851), үндсэн хаяг (p=0.011), одоо амьдарч буй орчин (p=0.050), ам бүлийн тоо (p=0.063), айлын хэддэх хүүхэд (p=0.057), гэрлэлтийн байдал (p=0.387) зэрэг үзүүлэлт нь статистикийн хувьд ач холбогдолгүй байсан бол нас (p=0.000), одоо эзэмшиж буй боловсролын түвшин (p=0.000), одоо суралцаж буй дамжаа (p=0.000), гэр бүлийн байдал (p=0.000), ЭЕШ-ийн оноо (p=0.001), зэрэг үзүүлэлтүүд нь статистикийн хувьд ач холбогдол бүхий байгаа нь тодорхойлогдлоо. Оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг Sorensen Self-Esteem Questionnaire сорилоор үнэлсэнээс нийт оюутнуудын 49 (6.68%) нь өөрийгөө үнэлэх үнэлэмж маш өндөр, 55 (7.5%) нь өөрийгөө үнэлэх үнэлэмж дунджаас дээгүүр түвшинд, 142 (19.4%) нь өөрийгөө үнэлэх үнэлэмж дундаж түвшинд, 487 (66.4%)нь өөрийгөө үнэлэх үнэлэмж маш бага гэж үнэлэв. (Зураг 1).



Зураг 1. Оюутнуудын ӨҮҮ-ийн түвшин

Оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нас, боловсрол, харъяалал, ам бүлийн үзүүлэлтээр харьцуулсан (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Оюутнуудын ӨҮҮ-ийг нас, боловсрол, харъяалал, ам бүлийн үзүүлэлтээр харьцуулсан дүн

№		Үзүүлэлт	Маш өндөр (0-4)		Дундажаас дээгүүр (5-10)		Дундаж (11-18)		Маш бага (19-50)	
			тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Насны үзүүлэлт	17-21	13	2.2%	22	3.8%	93	16.1%	452	77.9%
		22-43	36	23.5%	33	21.6%	49	32%	35	22.9%
2	Боловсрол	Бакалаврын	24	6.7%	36	10.1%	89	25.1%	207	58.1%
		Дипломын	25	6.6%	19	5.1%	53	14%	280	74.3%
3	Харъяалал	Улаанбаатар	32	12%	39	14.6	87	32.6%	109	40.8%
		Хөдөө орон нутаг	17	3.6%	16	3.4%	55	11.8%	378	81.2%
4	Ам бүл	1-3 ам бүлтэй	26	14.2%	24	13.2%	68	37.4%	64	35.2%
		4-6 ам бүлтэй	12	2.6%	18	3.9%	53	11.5%	379	82%
		7-9 ам бүлтэй	9	10.8%	12	14.5%	20	24.1%	42	50.6%
		10-аас дээш ам бүлтэй	2	33.3%	1	16.7%	1	16.7%	2	33.3%

Судалгаанд хамрагдсан 17-21 насны 580 (79.1%) оюутнаас 452 (61.7%) нь ӨҮҮ-ээ маш бага (19-50 оноо) гэж үнэлсэн байна. Оюутны бакалаврын болон дипломын боловсролын ӨҮҮ ялгаатай (p=0.000) байв. Өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр оюутнуудын 158 (64.2%) нь УБ хотоос суралцагч оюутнууд байсан ба хөдөө орон нутгаас суралцагч оюутнуудын 88 (35.8%) нь ӨҮҮ маш өндөр байгаа нь хот болон хөдөөгийн оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмж ялгаатайг харуулж байна. 4-6 ам бүлтэй 462 оюутны 379 (82.03%) нь ӨҮҮ маш бага гэж үнэлсэн.

Хэлцэмж: Өөрийгөө үнэлэх үнэлэмж нь өсвөр насандаа төлөвшин хөгждөг хувь хүний хөгжил төлөвшлийн суурь үзүүлэлт болох хэдий ч нийгэм орчны нөлөө, эдийн засаг, гэр бүлийн хүмүүжил зэргээс хамааран харьцангуй тогтвортой биш байдаг.[4] Өөрийгөө үнэлэх үнэлэмжид нас, хүйс, боловсролын түвшин, амьдралын орчин нөхцөл, гэр бүлийн байдал, гэр бүлийн хүмүүжил нөлөөлдөг байна.[5-8] Судлаач Helmy A нарын (2020) судалгааны үр дүнгээс харахад сувилахуйн оюутнуудын 48.1% нь өөрийгөө өндөр гэж тодорхойлсон байхад бидний судалгаанд хамрагдсан оюутнуудын 66.4% нь маш бага гэж үнэлсэн байгаа нь сувилахуйн оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ байна гэж үзэж байна.[9]

Судлаач Shrestha B (2021) нарын судалгаанд 18.9% нь өөрийгөө үнэлэх үнэлэмж багатай, 74.4% нь өөрийгөө үнэлэх үнэлэмж хэвийн, 6.7% нь өндөр оноотой байсан бөгөөд дундаж оноо (19.19±4.18) нь бидний судалгаанд оролцсон оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмжийн дундаж оноо (22.5±4.21)-той ойролцоо утгатай байв.[10]

Олон улсад хийгдсэн судалгаанаас харахад сувилахуйн оюутан нь өөртөө итгэлтэй өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр байх шаардлагатай гэж үзэж байгаа ч сувилахуйн оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмж дундаж болон дунджаас доогуур түвшинд өөрийгөө үнэлж байгаа нь тэдний нас, нийгэмд эзлэх байр суурь, сургалтын ачаалал, заавал эзэмших ур чадвартай холбоотой байна гэсэн дүгнэлтэд хүрч байгаа нь бидний судалгааны зорилготой ойролцоо байна.

Дүгнэлт: Сувилахуйн сургуулийн оюутнуудын өөрийгөө үнэлэх үнэлэмж нь (66.4%) бага байгаа нь тодорхойлогдлоо. Энэ нь тэдний нас, болон нийгэмд эзлэх байр суурь, мөн хүрээлэн буй орчны нөлөөлөл, ар гэр, багш, эцэг эхийн оролцоотой холбоотой байх магадлалтай учраас оюутан хэмээх бие хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж хөгжиж төлөвших насанд нь өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх аргад суралцуулах хэрэгцээ зайлшгүй шаардлагатай байна.

Ном зүй:

1. *Боловсролын тухай хууль. Улаанбаатар хот https://legalinfo.mn/mn/detail/9020;2002.*
2. *Дээд Боловсролын Тухай Хууль. Улаанбаатар https://legalinfo.mn/mn/detail/251; 2002.*
3. *Ж.Батдэлгэр, Д.Эрдэнэчулуун, Б.Туяа, Б.Оюунцэцэг. Хүний хөгжлийн сэтгэл судлал. Улаанбаатар2021.*
4. *Э.Мөнгөнтулга БДЦС. Өөртөө итгэх итгэл. Vol 1. Улаанбаатар: Мөнхийн үсэг; 2016.*
5. *Н.Бэгз, С.Санжаадамба, Б.ЭНхбаяр, Лхагвасүрэн Ц, Б.Баярмаа, Б.Баярсайхан. Хүүхэд залуучуудын хөгжлийн онол арга зүй. Улаанбаатар: Соёмбо пресс ХХК; 2018.*
6. *О.Мягмар. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд. Vol 1. Улаанбаатар: Ганпринт; 2012.*
7. *Б.Батсайхан, М.Дэлгэржав. Сэтгэл судлалын бага тайлбар толь. Vol 1. 1 ed. Улаанбаатар Мөнхийн үсэг; 2013.*
8. *Branden N. The psychology of self-esteem: a revolutionary approach to self-understanding that launched a new era in modern psychology. Jossey-Bass; 2001.*
9. *Helmy A, Faisal S, Hassan H. The Relationship between Student's Self Esteem and Problem Solving at Benha and Ain Shams Technical Institute of Nursing. Egyptian Journal of Health Care. 2018;9(2):190-207.*
10. *Shrestha B, Yadav S, Dhakal S, Ghimire P, Shrestha Y, Rathaure ES. Status of self-esteem in medical students at a college in Kathmandu: A descriptive cross-sectional study. F1000Research. 2021;10.*

A study of the self-esteem of nursing students

Munkhtuya B[1], Gankhuyag G[1], Oyungoo B[1]

[1]School of Nursing, MNUMS
E-mail: munkhtuya.ba@mnums.edu.mn, Tel: +976-98111985

Background: Everyone has the resources and ability to learn, and the problem of self-awareness, discovering the meaning of things by oneself, discovering one's interests, needs, and talents through self-evaluation, and self-development is a philosophical concept put forward by contemporary western and oriental thinkers and its theory have been playing an important role until now. Basis of learning is self-awareness and self-discovery; self-esteem is especially important for successful learning. The process of human development and its results largely depend on the individual's own active participation, self-requirements, and self-esteem. This need for self-awareness, self-respect, and self-confidence is constantly growing throughout a person's life. At every stage, people think about the meaning of life and search for what is most important to them. Believing that high self-esteem of students lays the foundation for their academic success and becoming competent professionals in the future, we believe that there is a need to learn the level of self-esteem of students, what are the factors affecting it, and how to increase this self-esteem? So, we decided to perform a research study about self-esteem of nursing students of the MNUMS /Mongolian National University of Medical Science/.
Aim: To determine the self-esteem of nursing students and to study the factors affecting it.
Materials and Methods: A survey was conducted using the self-evaluation questionnaire of Marilyn Sorensen to select students studying in the nursing program of the School of Nursing of NUMS /National University of Medical Science/. The research data has been statistically processed using SPSS-25 statistical software and Microsoft Excel software.
Results: The study included 356 (48.6%) undergraduate students and 377 (51.4%) students enrolled in the diploma program of the School of Nursing of MNUMS /Mongolian National University of Medical Science/, and a total of 733 students aged 17-43 participated, with an average age of 21.2. 49 (6.68%) of the surveyed students have very high self-esteem, 55 (7.5%) have above-average self-esteem, 142 (19.4%) have average self-esteem, and 487 (66.4%) have very low self-esteem.
Conclusions: 66.4% of students have very low self-esteem, which is probably related to their age and social status, as well as the influence of the environment, family, teachers, and parents. Therefore, at the age when the student's self-esteem is developing, they need the support of the school, teachers, family environment, parents and friends to improve their self-esteem.

Keywords: Self-esteem, Personal values